



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 326

Улаанбаатар
хот


Жагсаалт шинэчлэн батлах тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10¹.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглох оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан шинэчлэн тогтоох асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ч.ХҮРЭЛБААТАР

Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт

	Нэр (монгол хэлээр)	Нэр (англи хэлээр)
1	Ангиль	Anguilla
2	Андоррагийн Хант Улс	Andorra
3	Антигуа Барбуда	Antigua & Barbuda
4	Арабын Нэгдсэн Эмират	United Arab Emirates
5	Аруба	Aruba
6	Барбадос Улс	Barbados
7	Бахамын арлууд	Bahamas
8	Бахрейны Хаант Улс	Bahrain
9	Белиз Улс	Belize
10	Бермудын арал	Bermuda
11	Ботсвана	Botswana
12	Британийн Виржинийн арлууд	British Virgin Islands
13	Бруней	Brunei
14	Бүгд Найрамдах Вануату Улс	Vanuatu
15	Бүгд Найрамдах Кипр Улс	Cyprus
16	Бүгд Найрамдах Коста-Рика Улс	Costa Rica
17	Бүгд Найрамдах Либериа Улс	Liberia
18	Бүгд Найрамдах Ливан Улс	Lebanon
19	Бүгд Найрамдах Мавритан Улс	Mauritius
20	Бүгд Найрамдах Мальта Улс	Malta
21	Бүгд Найрамдах Панам Улс	Panama
22	Бүгд Найрамдах Уругвай Улс	Uruguay
23	Гернси	Guernsey
24	Гибралтар	Gibraltar
25	Гренад Улс	Grenada
26	Доминикийн Хамтын Нөхөрлөлийн Улс	Dominica
27	Жерси	Jersey
28	Ирланд Улс	Ireland
29	Кайманы арлууд	Cayman Islands
30	Куракао	Curacao
31	Куукийн арлууд	Cook Islands
32	Лихтенштейний ВантУлс	Liechtenstein
33	Люксембург	Luxembourg
34	Макао	Macao, SAR
35	Малайз	Malaysia
36	Маршаллын арлууд	Marshall Islands
37	Монако	Monaco
38	Монтсеррат Улс	Montserrat
39	Мэний арал	Isle of Man
40	Нидерландын Антилийн Арлууд	Netherlands Antilles
41	Самоагийн Тусгаар улс	Independent State of Samoa
42	Сейшелийн Арлын Бүгд Найрамдах Улс	Seychelles
43	Сент-Винсент-Гренадин Улс	St. Vincent and Grenadines
44	Сент-Китс-Невисийн Холбооны Улс	St. Kitts and Nevis
45	Сент-Люси Улс	St. Lucia
46	Сингапур	Singapore
47	Тёркс-кайкосын арлууд	Turks and Caicos Islands
48	Хонконг	Hong Kong, SAR
49	Швейцар	Switzerland